

## ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ СИСТЕМИЙН ШУГАМЫН ӨСГӨГЧ, ЧАНГА ЯРИГЧИЙН ШИНЭЭР СУУРИЛУУЛАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### Ажил нь дараах хэсгүүдээс тогтоно.

1. Тоног төхөөрөмжийг графикт хугацаанд нийлүүлнэ.
2. Чанга яригч/Цагаан хоолой/-г захиалагчийн заасан газарт суурилуулах, кабель татаж холбох.
3. Туршилт тохируулга хийх.

### Ерөнхий шаардлага

Энэхүү ажлыг гүйцэтгэхээр тендерт санал ирүүлэгч нь дараах техникийн тодорхойлолттой бүрэн танилцаж хүлээн зөвшөөрсний үндсэн дээр тендерт ирүүлэх саналыг бэлтгэсэн байна.

- Нийлүүлэх борлуулах аль нэг албан ёсны эрхийн гэрчилгээний /distributor, reseller, partner/ хуулбар ирүүлэх. /баримт бичгийг орчуулан ирүүлнэ/
- Баталгаат хугацаанд гарсан доголдлыг болон гэмтлийг өөрийн зардлаар шуурхай засварлах ажлыг хийж гүйцэтгэнэ.
- Ашиглалтын заавар, гарын авлагыг ирүүлнэ.
- Санал болгож буй барааг санал болгосон үнэдээ багтаан хугацаандаа нийлүүлэхийг /Баталсан албан бичиг ирүүлнэ/
- Нийлүүлэх тоног төхөөрөмж нь  
Шугамын өсгөгч- 1ш.  
Гадна спикер /Цагаан хоолой/-20ш  
Дотор спикер-15ш  
Зарлан мэдээлэх системийн чанарын шаардлага хангахгүй байгаа 1000 м кабелийг хэсэгчилж солино.
- Баталгаат хугацаа: 1 жил ба түүнээс дээш.

№	Нэр төрөл	Шаардлага үзүүлэлт
1	Гадна спикер/цагаан хоолой/ болон дотор спикер	-Гадна спикер /Цагаан хоолой/ нь тоос, шороо, ус чийгны хамгаалалттай, зохих стандартуудыг хангасан байх, гадна суурилуулж ашиглах зориулалттай байна. -Дуу, хүний яриаг тод ойлгомжтой зарладаг байх. -Гадна спикер нь хатуу материалаар хийгдсэн байх, дотор спикер нь ABS хуванцар байж болно. -Гадна спикер гаралтын чадал 50Ватт, дотор спикер гаралтын чадал 5-10 Ватт байх.

2	Шугамын өсгөгч	<ul style="list-style-type: none"> <li>- Өсгөгч нь холбогдсон чанга яригчийг нэгдсэн эсвэл бүсчилсэн байдлаар зарлах боломжтой байх.</li> <li>- Өсгөгч нь чанга яригчийн чадлаас хамаарсан олон гаралттай байх.</li> <li>-2000 Ватт болон дээш чадалтай байх.</li> <li>- Онцгой нөхцөлд буюу ямар нэг тэжээлийн эх үүсвэргүй нөхцөлд өөрийгөө тэжээх боломжтой.</li> <li>- Өсгөгч нь AUX, USB, BLUETOOTH аль нэг оролттой байх.</li> <li>- Цахилгааны богино холболт болон халалтын хамгаалалттай байх.</li> </ul>
---	----------------	--

Зарлан мэдээлэх системийн шугамын өсгөгч, зарим чанга яригчийг солих, кабель шугамд өөрчлөлт оруулах ажлыг гүйцэтгэх сонирхолтой иргэн аж ахуйн нэгжүүд 2021 оны 07 сарын 09-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө [tpp2@tpp2.energy.mn](mailto:tpp2@tpp2.energy.mn) хаягаар нийлүүлэх үнэ, хугацаа, техникийн бичиг баримтыг ирүүлнэ үү. Сонирхсон этгээд холбогдох мэдээллийг дараах хаягаар холбогдож авна уу.

Баянзүрх дүүрэг. 20-р хороо. ДЦС-2 ТӨХК. 109 тоот. Худалдан авах ажиллагааны хэсэг. Утас 70172157